



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014. 05. 21 № 14Г-ГА/2014/01-ГА 02/17

ХӨДӨЛМӨРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
П.ГАНТУЛГА ТАНАА

Зөрчлийг арилгуулах тухай

Үндэсний аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Хөдөлмөрийн сайдын багцад улсын төсвийн хөрөнгөөр 2013 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүнд аudit хийх явцад ТЕЗ-аас эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын ажилд дараах зөрчил илэрлээ.

Аудитаар нийт 574.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь ашиглалтанд хүлээлгэн өгсөн зарим засварын ажил чанарын шаардлага хангаагүйтэй холбоотой байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”-ын 4.2-т “Захиалагч барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын, шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүрт нь арилгуулах арга хэмжээ авч ажиллах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх” гэж заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Чанаргүй хийгдсэн их засварын ажлыг гүйцэтгэгч компаниар дахин хийлгэж, зөрчлийг арилгах арга хэмжээ авах
2. Зөрчлийг арилгуулах талаар авсан арга хэмжээний тухай хариуг 2014 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх


АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Д.ГАНДОЛГОР

АУДИТОР

Э.УЯНГА



**Хугацаандаа ашиглалтад ороогүй, чанаргүй хийгдсэн засварын
ажлын жагсаалт**

(сая төгрөгөөр)

<i>Төсөл арга хэмжээний нэр</i>	<i>Төсөөвт өртөг</i>	<i>Зөрчил</i>
Хөвсгөл аймгийн MCYT-ийн авто засварын дадлагын газрын барилга	163.4	барилга угсралтын гүйцэтгэлтэй биечлэн танилцахад усны хаялга хийгээгүй, дотор сантехникийн холболтыг муу хийснээс ус алдсан, бие засах өрөөний тааз нь доошоо түмбийсэн, агааржуулалтын хоолой байгаа боловч ажиллахгүй байгаагаас цонх нь хөлөрсөн зөрчлүүд илэрсэн байна.
Архангай аймгийн MCYT-ийн дотуур байрны засварын ажил	235.0	ажлын гүйцэтгэлтэй биечлэн танилцахад бие засах өрөөнөөс ус алдсан, зарим цонх цууралт өгсөн, бүх цонхны гадна амалгаа хийгдээгүй байна.
Завхан аймгийн MCYT-ийн дадлагын байрны засварыг	175.8	биечлэн шалгахад гадна хаяавчийн хананд вааранцар хавтан наагаагүй, үүдний хэсгийг өнгөт хавтангаар хийгээгүй байна.
Дүн	574.2	